

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ, БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ХОЁР ҮЕ ШАТТАЙ ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: СНАГ-2024/10/НА-СТА-ТХН

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2024 он

Санхүү-Нийцлийн газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Ч.Болд
Утас: 260512 Цахим хаяг: boldch@audit.mn
Аудитор: П.Ариунзаяа
Утас: 261885 Цахим хаяг: ariunzayap@audit.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч: Оюу эрдэм аудит ХХК-ийн
Гүйцэтгэх захирал: Н.Цацрал
Утас: 94493362 Цахим хаяг: oyuerdem.audit@mongolnet.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЖИЖИГ ДУНД ҮЙЛДВЭРИЙГ ХӨГЖҮҮЛЭХ,
БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХОЁР ҮЕ
ШАТТАЙ ЗЭЭЛИЙН ТӨСЛИЙН
ЗОХИЦУУЛАГЧ Ж.ТҮВШИНТӨГС ТАНАА

2024.02.23 № 07/359
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төслийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

"Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх, Байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл"-ийн 1 дүгээр үе шат 2006-2010 онд, 2 дугаар үе шат 2011-2015 оны хооронд амжилттай хэрэгжсэн. Төслийн зээлийн үндсэн эх үүсвэр 2015 онд бүрэн олгогдож дууссанаас хойш төслийн хэрэгжилт эргэн төлөлтийн сангийн эх үүсвэрээр тогтвортой хэвийн үргэлжилж, тайлант хугацаанд төслийн зээлийн эргэн төлөлт гэрээт банкнуудаас бүрэн төлөгдсөн байна.

Аудитын гол асуудал

ХААХҮЯ болон Капитал банкны эрх хүлээн авагч нарын хооронд хийсэн "Өр төлбөр барагдуулж, үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх" тухай гэрээнүүдийг ХХААХҮСайд тайлант онд баталж, гэрээний дагуу 12,780,308.7 мянган төгрөгийн хөрөнгийг өр төлбөрт хүлээн авсан байна.

Бусад асуудлын хэсэг

Зээлийн эргэн төлөлтөөс жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр 46 аж ахуйн нэгжид 19,821,081.4 мянган төгрөг, байгаль орчныг хамгаалах чиглэлээр 3 аж ахуйн нэгжид 1,910,000.0 мянган төгрөгийн зээлийг шинээр олгосон байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн тухай олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж, бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,315,661,011.18	121,431,200,836.64
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	26,542,520,662.95	19,800,495,533.75
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	26,542,520,662.95	19,800,495,533.75
31210	Төгрөг	25,581,190,637.78	18,848,629,220.24
31211	Төрийн сангийн харилцах	0.20	-
31212	Монгол банкин дахь харилцах	25,581,190,637.58	18,848,629,220.24
31220	Гадаад валют	961,330,025.17	951,866,313.51
31222	Монгол банк дахь харилцах	961,330,025.17	951,866,313.51
33	АВЛАГА	100,770,653,548.23	88,847,006,520.85
33400	Зээлийн хүүгийн авлага	336,491,017.93	-
33402	Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	1,366,317.50	-
33500	Бусад авлага	991,447,718.65	-
33510	Байгууллагаас авах авлага	991,447,718.65	-
33600	Зээлийн авлага	99,441,348,494.15	88,847,006,520.85
33610	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	99,441,348,494.15	88,847,006,520.85
33615	Хувийн хэвшлийн ААН-д олгосон зээл	99,441,348,494.15	88,847,006,520.85
35	БАРАА МАТЕРИАЛ	2,486,800.00	12,783,698,782.04
35400	Хангамжийн материал	2,486,800.00	12,783,698,782.04
35410	Бичиг хэргийн материал	0.00	256,500.00
35470	Бусад хангамжийн материал	2,486,800.00	12,783,442,282.04
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	10,724,600.20	6,781,881.12
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	10,724,600.20	6,781,881.12
39200	Биет хөрөнгө	10,669,600.20	6,781,881.12
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	34,462,345.00	34,462,345.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(23,852,744.80)	(27,740,463.88)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	13,779,151.51	13,779,151.51
39208	Хуримтлагдсан элэгдэл	(13,779,151.51)	(13,779,151.51)
39217	Ном	60,000.00	60,000.00
39300	Биет бус хөрөнгө	55,000.00	-
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(825,000.00)	(880,000.00)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	127,326,385,611.38	121,437,982,717.76
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	179,316,320,731.76	160,670,650,790.27
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,582.46	-
41300	Өглөг	4,582.46	-
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	4,582.46	-
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	179,316,316,149.30	160,670,650,790.27
42200	Урт хугацаат зээл	179,316,316,149.30	160,670,650,790.27
42220	Гадаад валют	179,316,316,149.30	160,670,650,790.27
42224	Төслийн зээл	179,316,316,149.30	160,670,650,790.27
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	(51,989,935,120.38)	(39,232,668,072.51)
51	Засгийн газрын хувь оролцоо	(51,989,935,120.38)	(39,232,668,072.51)
51200	Хуримтлагдсан үр дүн	(51,989,935,120.38)	(39,232,668,072.51)
51210	Өмнөх үеийн үр дүн	(43,748,638,440.24)	(51,989,935,120.38)
51220	Тайлант үеийн үр дүн	(8,241,296,680.14)	12,757,267,047.87
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	127,326,385,611.38	121,437,982,717.76

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	1,853,212,465.62	2,157,787,404.66
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,853,212,465.62	1,788,657,304.66
120	Нийтлэг татварын бус орлого	1,853,212,465.62	1,788,657,304.66
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,840,001,065.42	1,788,657,304.66
1200046	Зээлийн хүүгийн орлого	1,840,001,065.42	1,788,657,304.66
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Ү.Хөрөнгө	10,724,600.20	-
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа	2,486,800.00	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	369,130,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	-	369,130,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	369,130,100.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,138,827,429.80	1,553,579,704.16
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,138,827,429.80	1,553,579,704.16
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	294,849,616.08
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	-	27,420,000.00
210304	Байрны түрээс	-	27,420,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	6,257,312.00
210401	Бичиг хэрэг	-	2,100,100.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,430,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	677,601.00
210404	Ном, хэвлэл	-	798,800.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,250,811.00
2107	Томилолт, зочны зардал	-	15,765,990.00
210702	Дотоод албан томилолт	-	15,765,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	235,953,595.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	235,953,595.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,452,719.08
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,510,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	3,942,719.08
211	ХҮҮ	1,138,827,429.80	1,180,048,450.04
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,138,827,429.80	1,180,048,450.04
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	1,138,827,429.80	1,180,048,450.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	78,681,638.04
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	78,681,638.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	78,681,638.04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	714,385,035.82	604,207,700.50
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	166,277,060.74	12,170,055,514.87
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	166,277,060.74	12,170,055,514.87
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	9,121,958,776.70	16,996,167.50
225004	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	9,121,958,776.70	16,996,167.50
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(8,241,296,680.14)	12,757,267,047.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	49,578,853,982.01	16,547,698,532.50
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,001,348,152.21	22,661,710,732.50
120	Нийтлэг татварын бус орлого	42,001,348,152.21	22,661,710,732.50
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,001,348,152.21	22,661,710,732.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,624,543,800.00	20,873,053,427.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,654,524,476.66	-
1200046	Зээлийн хүүгийн орлого	1,840,001,065.42	1,788,657,304.66
1200047	Шилжиж ирсэн мөнгөн хөрөнгө	21,882,278,810.13	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	7,577,505,829.80	(6,114,012,200.00)
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	7,577,505,829.80	(6,114,012,200.00)
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	-	369,130,100.00
131004	Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	7,577,505,829.80	(6,483,142,300.00)
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	1,549,178,550.04
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	1,549,178,550.04
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	290,448,461.96
2103	Байр ашиглалттай холбоотой зардал	-	27,420,000.00
210304	Байрны түрээс	-	27,420,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	5,451,712.00
210401	Бичиг хэрэг	-	2,203,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	677,601.00
210404	Ном, хэвлэл	-	892,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	1,678,611.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	278,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	278,900.00
2107	Томилолт, зочны зардал	-	17,195,990.00
210702	Дотоод албан томилолт	-	17,195,990.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	234,591,859.96
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	234,591,859.96
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,510,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,510,000.00
211	ХҮҮ	-	1,180,048,450.04
2111	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,180,048,450.04
211101	Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,180,048,450.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	78,681,638.04
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	78,681,638.04
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	78,681,638.04
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	49,578,853,982.01	14,998,519,982.46

VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	(23,036,333,319.06)	(21,740,545,111.66)
14	Бусад эх үүсвэр	165,716,310.74	7,532,455.84
145001	Гадаад валютын ханшийн зөрүүний олз	165,716,310.74	7,532,455.84
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	23,202,049,629.80	21,731,081,400.00
230001	Эргэж төлөгдөх зээл	23,202,049,629.80	21,731,081,400.00
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	16,996,167.50
250001	Гадаад валютын ханшийн зөрүүний гарз	-	16,996,167.50
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	26,542,520,662.95	(6,742,025,129.20)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,542,520,662.95	19,800,495,533.75

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	-	-
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(43,748,638,440.24)	(43,748,638,440.24)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(43,748,638,440.24)	(43,748,638,440.24)
4	Тайлант үеийн үр дүн	-	-	(8,241,296,680.14)	(8,241,296,680.14)
5	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-	(51,989,935,120.38)	(51,989,935,120.38)
6	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	-	-	(51,989,935,120.38)	(51,989,935,120.38)
7	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	-	-	(51,989,935,120.38)	(51,989,935,120.38)
8	Тайлант үеийн үр дүн	-	-	12,757,267,047.87	12,757,267,047.87
9	2023 оны 6-р сарын 30-наарх үлдэгдэл	-	-	(39,232,668,072.51)	(39,232,668,072.51)

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	(6,114,012,200.00)	23,201,578,312.00	17,087,566,112.00	379.5
УРСГАЛ ЗАРДАЛ	369,130,100.00	1,470,496,912.00	1,101,366,812.00	398.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	369,130,100.00	290,448,461.96	78,681,638.04	78.7
Байр ашиглалттай холбоотой зардал	29,641,200.00	27,420,000.00	(2,221,200.00)	92.5
Байрны түрээс	29,641,200.00	27,420,000.00	(2,221,200.00)	92.5
Хангамж, бараа материалын зардал	18,349,400.00	5,451,712.00	(12,897,688.00)	29.7
Бичиг хэрэг	9,174,700.00	2,203,200.00	(6,971,500.00)	24.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,823,200.00	677,601.00	(1,145,599.00)	37.2
Ном, хэвлэл	5,391,100.00	892,300.00	(4,498,800.00)	16.6
Бага үнэтэй, түргэн элэгдэх, эд зүйлс	1,960,400.00	1,678,611.00	(281,789.00)	85.6
Эд хогшил, урсгал засвар зардал	9,606,000.00	278,900.00	(9,327,100.00)	2.9
Багаж, техник, хэрэгсэл	9,606,000.00	278,900.00	(9,327,100.00)	2.9
Томилолтын зардал	17,578,900.00	17,195,990.00	(382,910.00)	97.8
Дотоод албан томилолт	17,578,900.00	17,195,990.00	(382,910.00)	97.8
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	279,545,700.00	234,591,859.96	(44,953,840.04)	83.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	279,545,700.00	234,591,859.96	(44,953,840.04)	83.9
Бараа үйлчилгээний бусад зардал	14,408,900.00	5,510,000.00	(8,898,900.00)	38.2
Бараа үйлчилгээний бусад зардал	14,408,900.00	5,510,000.00	(8,898,900.00)	38.2
ХҮҮ	-	1,180,048,450.04	1,180,048,450.04	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,180,048,450.04	1,180,048,450.04	-
Гадаад зээлийн үйлчилгээний төлбөр	-	1,180,048,450.04	1,180,048,450.04	-
ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	21,731,081,400.00	15,247,939,100.00	335.2
Эргэж төлөгдөх зээл	(6,483,142,300.00)	21,731,081,400.00	15,247,939,100.00	335.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(6,114,012,200.00)	14,759,041,227.84	8,645,029,027.84	241.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	369,130,100.00	369,130,100.00	-	100.0
Улсын төсвөөс санхүүжих	369,130,100.00	369,130,100.00	-	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	-	20,873,053,427.84	20,873,053,427.84	-
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	20,873,053,427.84	20,873,053,427.84	-
БУСАД ЭХ ҮҮСВЭР	(6,483,142,300.00)	(6,483,142,300.00)	-	100.0
Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх	(6,483,142,300.00)	(6,483,142,300.00)	-	100.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	19,800,495,533.75	19,800,495,533.75	-
АЖИЛЛАГСАДЫН ТОО	5	5	-	100.0
Удирдах ажилтан	1	1	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	4	4	-	100.0

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

3.1 Аудитаар нийт 163.9 мянган төгрөгийн алдаа¹ илэрснийг аудитын явцад бүрэн залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мян.төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Үндсэн хөрөнгийн элэгдэл илүү тооцож, зардал нэмэгдүүлсэн байна.	1	163.9	-	-	1	163.9	1	163.9	-	-	1	163.9
Дүн	1	163.9	-	-	1	163.9	1	163.9	-	-	1	163.9

3.2 АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Газар болон үл хөдлөх хөрөнгүүдийн үл хөдлөх хөрөнгийн улсын бүртгэлийн болон газар эзэмших гэрчилгээг ХХААХҮЯ-ны эзэмшилд шилжүүлж авах зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мян.төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Газар, үл хөдлөх хөрөнгө ҮХЭХӨУБ-ийн гэрчилгээ "Төлбөр авагч, өмчлөх, эзэмших эрх шилжүүлэн авагч"-ийн нэр дээр шилжүүлээгүй	1	-	-	-	-	-	1	-
Дүн	1	-	-	-	-	-	1	-